

## **“ Залуу судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, грант олгох журам”**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журам нь залуу эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал (цаашид “бага хурал” гэх)-ыг зохион байгуулах, бага хурлаас шалгарсан шилдэг залуу судлаачдад шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн сайдын нэрэмжит судалгааны грант (цаашид “грант” гэх) олгох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Залуу судлаачдын эрдэм шинжилгээний ажлын үр дүнг шүүн хэлэлцэж, өндөр ач холбогдол бүхий шилдэг илтгэлийг шалгаруулах зорилгоор бага хурлыг жил бүр энэ журмын 2.2-т заасан салбаруудаар зохион байгуулна.

1.3. Бага хуралд Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.2-т заасан эрдэм шинжилгээний байгууллагад ажиллаж буй 35 хүртэлх насны залуу эрдэмтэн, судлаач, багш нар оролцоно.

1.4. Эрдэмтдийн залгамж халаа, тэргүүний залуу судлаачдыг бэлтгэх зорилгоор бага хурлаас шилдэг бүтээлээрээ шалгарсан 10 хүртэлх залуу судлаачдад Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын нэрэмжит грант олгоно.

### **Хоёр. Бага хурал зохион байгуулах**

2.1. Бага хурлыг зохион байгуулах, шилдэг судлаачдыг шалгаруулах ажлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан нэгж, Шинжлэх ухаан, технологийн сан, Шинжлэх ухааны академи, Залуу эрдэмтдийн холбоо хамтран гүйцэтгэнэ.

2.2 Бага хуралд оролцогч нь дор дурдсан шинжлэх ухааны салбараар илтгэл тавьж хэлэлцүүлнэ:

- 2.2.1. Байгалийн ухаан;
- 2.2.2. Техник технологи;
- 2.2.3. Анагаах ухаан;
- 2.2.4. Биологи-Хөдөө аж ахуй;
- 2.2.5. Нийгмийн ухаан;
- 2.2.6. Геологи,Газарзүй.

2.3. Бага хурлын бэлтгэл ажлыг зохион байгуулагч талуудын төлөөлөл оролцсон Ажлын хэсэг хариуцна.

2.4. Ажлын хэсэг нь доор дурдсан үүрэг хүлээнэ:

2.5.1. Бага хурлын товыг тогтоох;

2.5.2. Бага хуралд ирүүлэх илтгэлд тавигдах шаардлага, хэлэлцүүлэх илтгэлүүдийг урдчилан тодорхойлох;

2.5.3. Шинжлэх ухааны салбар тус бүрээр тавигдах илтгэлийг сонгон шалгаруулж, бага хурлаар хэлэлцүүлэхэд бэлтгэх;

2.5.4. Судлаачдаас ирүүлсэн илтгэлийг нэгтгэн бүртгэж, Ажлын хэсгээр хэлэлцүүлэн, шаардлага хангасан бүтээлүүдээр эмхтгэл хэвлүүлэх;

2.5.5. Бага хурлыг зохион байгуулахад шаардагдах зардлын тооцоог гаргаж Шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргэх;

2.5.6. Бага хурлын үеэр дотоод, гадаадын нэрт эрдэмтдийг урьж лекц уншуулах, уулзалт ярилцлага зохион байгуулах арга хэмжээ авах;

2.5. Бага хуралд оролцогч нь хурлын тов зарлагдсанаас хойш 45 хоногийн дотор доорхи материалыг бүрдүүлэн илтгэлийн хамт Залуу эрдэмтдийн холбоонд ирүүлнэ. Үүнд:

2.5.1. Бага хуралд оролцуулах тухай харъяалагдах эрдэм шинжилгээний байгууллагын эрдмийн зөвлөлийн хурлын протокол;

2.5.2. Судалгааны ажлын үр дүнгийн тодорхойлолт;

2.5.3. Бүтээлийн жагсаалт;

2.5.4. Грантаар хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, зардлын нарийвчилсан тооцоо.

2.6. Орон нутгийн эрдэм шинжилгээний байгууллагаас ирүүлсэн илтгэлийг журмын 2.5-д заасан шаардлагыг хангасан гэж үзвэл комисс хэлэлцэн материалыг нь үндэслэн дүгнэлт гаргаж болно.

### Гурав: Шилдэг судлаачдыг шалгаруулах

3.1. Залуу судлаачдыг сонгон шалгаруулах комиссыг 2.1-д заасан байгууллагуудын төлөөлөлтэйгээр байгуулж Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд батална.

3.2. Сонгон шалгаруулах комиссын дүгнэлтийг үндэслэн залуу судлаачдад грант олгох асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар шийдвэрлэнэ.

3.3. “Грант” нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 3.1.6 - д хамрагдах бөгөөд грантыг эрдмийн зэрэг хамгаалах бүтээлээ боловсруулах,

судалгааны ажлынхаа онол, туршилт, үйлдвэрлэлийн үр дүнг бататгах зэрэгт зориулан ашиглана.

3.4. Шилдэг судлаачийг шалгаруулахдаа дараах үзүүлэлтийг харгалзана:

3.4.1. судалгааны ажлын онолын болон практик ач холбогдол;

3.4.2. судалгааны ажлын шинэлэг, дэвшилттэй тал, үр дүнг хэрэглээ болгох боломж;

3.4.3. Грант горилогчийн эрдэм шинжилгээний ажлын арга зүй, түүнийг эзэмшсэн дадлага туршлага, чадвар;

3.4.4. Грант горилогч хамтын бүтээлд оролцсон бол оролцооны хувь, бие даан гүйцэтгэсэн байдал

### **Дөрөв. Грантыг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, тайлагнах**

4.1. Грант олгох, хурал зохион байгуулах үйл ажиллдагаанд шаардагдах зардлыг Шинжлэх ухаан, технологийн сангаас санхүүжүүлнэ.

4.2 . Нэг судлаачид олгох грантын хэмжээ 4 сая төгрөг байна.

4.3. Грантыг нэг удаа бүтнээр олгоно.

1.4. Судлаач нь грант авсан судалгааны ажлаа хэрэгжүүлэх явц, хөрөнгийн зарцуулалтын талаархи тайлангаа Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

-----oO-----